

## ЗЭЭЛИЙН НЭМЭЛТ ГЭРЭЭ

2022 оны 04-р сарын 07-ны өдөр

№ 3Г/СС201229001-1-2,  
№ЭТТ-2021/497-2

Улаанбаатар хот

Энэхүү ЗЭЭЛИЙН НЭМЭЛТ ГЭРЭЭ (цаашид "Гэрээ" гэх) – г Монгол улсын Иргэний хуулийн 451-ээс 453 - р зүйл, Банкны тухай хуулийн 10-р зүйл, Банк эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, мөнгөн хөрөнгийн шилжүүлэг, зээлийн үйл ажиллагааны тухай хуулийн 4-р бүлэг, Зээлийн мэдээллийн тухай хууль, 2022 оны 04-р сарын 05-ны өдрийн Худалдаа, хөгжлийн банкны Зээлийн хорооны хурлын СС20220405014 тоот шийдвэр, ЭРДЭНЭС ТАВАН ТОЛГОЙ ХК-ийн хүсэлтийг тус тус үндэслэн

Нэг талаас УЛААНБААТАР ХОТ, СУХБААТАР ДҮҮРЭГ, 1-Р ХОРОО, ЭНХТАЙВАНЫ ӨРГӨН ЧӨЛӨӨ 19, 14210 хаягт орших ХУДАЛДАА ХӨГЖЛИЙН БАНК (цаашид "Банк" гэх)

Нөгөө талаас УЛААНБААТАР ХОТ, ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРЭГ, ЖИГЖИДЖАВ-8, ФИНАНС ТӨВ хаягт орших ЭРДЭНЭС ТАВАН ТОЛГОЙ ХК (Регистрийн дугаар: 5435528) (цаашид "Зээлдэгч", Банк болон Зээлдэгчийг хамтад нь "Талууд" гэх) болон зээлийн гэрээгээр хүлээсэн үүргийн гүйцэтгэлийг хангах барьцаалуулагч УЛААНБААТАР ХОТ, ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРЭГ, ЖИГЖИДЖАВ-8, ФИНАНС ТӨВ хаягт орших ЭРДЭНЭС ТАВАН ТОЛГОЙ ХК (Регистрийн дугаар: 5435528) нар 2021 оны 07-р сарын 07-ны өдөр байгуулсан №3Г/СС201229001-1 (№ЭТТ-2021/497) тоот Зээлийн гэрээнд дараах нэмэлт, өөрчлөлтийг оруулахаар харилцан тохиролцов.

1. Талуудын хооронд 2021 оны 07-р сарын 07-ны өдөр байгуулсан №3Г/СС201229001-1 (№ЭТТ-2021/497) тоот Зээлийн гэрээний дараах хэсгүүдийг доор дурдсан байдлаар өөрчлөв. Үүнд:

1/ "3.1. Банк зээлдэгчид олгосон

- 29,999,999,113.20 (хорин есөн тэрбум есөн зуун ерэн есөн сая есөн зуун ерэн есөн мянга нэг зуун арван гурван төгрөг хорин мөнгө) төгрөгийн үлдэгдэлтэй зээлийг шилжүүлэг хийх өдрийн Монголбанкны албан ханшаар ам.долларт хөрвүүлнэ."

2/ "3.2. Зээлийн үндсэн болон хэтэрсэн хугацааны хүү:

- жилийн 6.50 хувь (энэхүү хүү нь ам.долларт шилжсэн өдрөөс эхлэн тооцогдоно.)

3/ "4.1. Зээлийн хугацаа:


- 18 сар (энэ хугацаа нь 2022 оны 12-р сарын 30-ны өдрийг хүртэл тооцогдоно)"

2. Талуудын хооронд 2021 оны 07-р сарын 07-ны өдөр байгуулсан №3Г/СС201229001-1 (№ЭТТ-2021/497) тоот Зээлийн гэрээний Хавсралт 1-ийг энэхүү гэрээний Хавсралт 1-ээр өөрчлөв.
3. Гэрээ нь 2021 оны 07-р сарын 07-ны өдөр байгуулсан №3Г/СС201229001-1 (№ЭТТ-2021/497) тоот Зээлийн гэрээ, №ЗБ/СС201229001-1-1 (№ЭТТ-2021/498) тоот Хөдлөх эд хөрөнгө болон эдийн бус хөрөнгийн барьцааны гэрээ, 2022 оны 01-р сарын 24-ний өдөр байгуулсан №3Г/СС201229001-1-1 (№ЭТТ-2021/497-1) тоот Зээлийн нэмэлт гэрээнүүд нь зээлдэгч гэрээгээр хүлээсэн үүргээ бүрэн биелүүлж дуусах хүртэл хугацаанд хэвээр үйлчилнэ.
4. Банк болон зээлдэгчийн хооронд 2021 оны 07-р сарын 07-ны өдөр байгуулсан №3Г/СС201229001-1 (№ЭТТ-2021/497) тоот Зээлийн гэрээний бусад зүйл, хэсэг, заалтууд хүчин төгөлдөр үйлчилнэ.
5. Гэрээ нь зээлдэгчээс зээлийн бүх төлбөрийг бүрэн гүйцэтгэж дуусах хүртэл хугацаанд хүчин төгөлдөр байна.
6. Гэрээ нь талуудын бүрэн эрхт төлөөлөгч нар гарын үсэг зурж (хуулийн этгээдийн хувьд тамга, тэмдэг дарж), нотариатаар гэрчлүүлснээр хүчин төгөлдөр болно.
7. Гэрээг 3 эх хувь үйлдэж, хоёр тал тус бүр нэг хувийг хадгалсан нь хуулийн адил хүчинтэй байна.

Гэрээ байгуулсан:

**Банкийг төлөөлж:**

Байгууллагын бизнесийн хяналтын хэлтсийн захирал:

 Г.ЭРДЭНСУВД  
Ахлах мэргэжилтэн  
 Э.АЛУНГУА  
Хяналтын мэргэжилтэн  
 А.ӨНӨРБУЯН

**Зээлдэгч/барьцаалуулагчийг төлөөлж:**

ЭРДЭНЭС ТАВАНТОЛГОЙ ХК -ийн Гүйцэтгэх захирал

 Б.АНХУЯГ  
JSC

**ЭРДЭНЭС ТАВАНТОЛГОЙ ХК-ИЙН 29,999,999,113.20 ТӨГРӨГТЭЙ ТЭНЦЭХ  
 АМ.ДОЛЛАРЫН ЗЭЭЛИЙН ЗЭЭЛ, ХҮҮНИЙ ЭРГЭН ТӨЛӨХ ХУВААРЬ**

1. Үндсэн зээл төлөх хуваарь

(ам.доллар)

| Зээлийн үндсэн төлбөр төлөх огноо | Үндсэн зээл төлөлт    |
|-----------------------------------|-----------------------|
| 2022 оны 10-р сарын 30-ны өдөр    | 3,370,000.00          |
| 2022 оны 11-р сарын 30-ны өдөр    | 3,370,000.00          |
| 2022 оны 12-р сарын 30-ны өдөр    | 3,320,666.00*         |
| <b>Бүгд</b>                       | <b>10,060,665.52*</b> |

\* Ам.долларын зээлд шилжих өдрийн Монголбанкны албан ханинаас хамаарч өөрчлөгдөж болно.

2. Зээлийн хүүг сар бүрийн 30-нд багтаан төлж барагдуулна.

**Гэрээ байгуулсан:**

**Банкийг төлөөлж:**

Байгууллагын бизнесийн хяналтын хэлтсийн  
 захирал:

  
 Г.ЭРДЭНЭСУВД  
 Ахлах мэргэжилтэн  
  
 З.АЛУНГУА  
 Хяналтын мэргэжилтэн  
  
 А.ӨНӨРБУЯН

**Зээлдэгч/барьцаадуулагчийг төлөөлж:**

ЭРДЭНЭС ТАВАНТОЛГОЙ ХК-ийн Гүйцэтгэх  
 захирал

  
 Б.ГАНХУЯГ

